

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Соёлын өвийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/177/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг:naranchimeg@audit.gov.mn Аудитын менежер: И.Эрдэнэцэцэг Утас: 260512 Цахим хаяг: erdenetsetsegi@audit.gov.mn Ахлах аудитор:Б.Лхагвацэнд Утас:260512 Цахим хаяг: Lkhagvatsendb@audit.gov.mn “Ирмүүн хантайшир аудит” ХХК-ийн захирал:Д.Бямбацэрэн Утас:77550809 Цахим хаяг:irmuunkhantaishir@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
МБШТ	Монголын бурхан шашинтны төв
ССАЖЗЯ	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
САГ	Санхүүгийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СӨҮТ	Соёлын өвийн үндэсний төв
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт



СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЗАХИРАЛ Г.ЭНХБАТ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/460
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1,8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Соёлын өвийн үндэсний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь бидний тогтоосон 36,973.0 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшингээс давсан бөгөөд шинж чанарын хувьд материаллаг, дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 432,740.2 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаагаас цаашид ашиглах боломжтой эсэхийг тодорхойлж, ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоогоогүй, санхүүгийн тайланг бодит үнэ цэнээр тайлагнаагүй, хөрөнгийг дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй;
- Соёлын өвийн үндэсний төвийн хэрэгжүүлж буй төслийн хүрээнд нийт 26,041.2 мянган төгрөгийг төслийн удирдагчийн цалин, санхүүгийн ажилтны урамшуулалд захирлын тушаалыг үндэслэн олгосон;

- Мөн төслийн хүрээнд томилолт, автомашины түрээсийн зардалд 21,462.0 мянган төгрөг, орчуулагчийн төлбөрт 14,200.0 мянган төгрөг, нийт 35,662.0 мянган төгрөгийн сонирхлын зөрчилтэй гүйлгээ хийсэн байх эрсдэлтэй байна.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.9, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 3, 31 дүгээр зүйлийн 31.3.2, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1 заалтуудтай тус тус нийцээгүй бөгөөд эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Соёл спорт аялал жуулчлал Залуучуудын яамтай хамтран “Өчигдрөөр ирээдүйг харахуй” Монгол оросын хамтарсан сэргээн засварлагчдын анхдугаар бага хурлыг 2025 оны 05 сард зохион байгуулж, 22,909.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Соёлын өвийн үндэсний төв нь Юнеско олон улсын байгууллагын санхүүжилтээр Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг бэхжүүлэх төслийн 135,039.3 мянган төгрөг, Хоол хүнсний соёл өв уламжлал ба цахим хэрэгжүүлэлт төслийн 48,099.7 мянган төгрөг, Монгол улсын соёлын биет бус өвийг хамгаалах чадавхыг бэхжүүлэх үндэсний сургагч багш бэлтгэх 45,618,5 мянган төгрөг, Монгол улсын соёлын биет бус өвийг түгээн сурталчлах бие даасан цахим талбарт хөгжүүлэлт хийх 27,062.0 мянган төгрөг нийт 255,819.5 мянган төгрөгийн төсөл хэрэгжүүлэн нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан. Мөн Монголын Бурхан Шашинтны Төв Гандантэгчэнлин хийдийн сүм дуганы өнгө будгийг сэргээх засварлах 89,716.0 мянган төгрөгийн ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Бусад асуудал

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартын дагуу хууль, тогтоомжийн хэрэгжилтэд нэмэлт горим, сорил гүйцэтгэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *В.Н* Ц.НАРАНЧИМЭГ



Соёлын өвийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	626,464,133.64	387,423,360.69
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	
33	АВЛАГА	101,228,684.20	25,021,514.20
33300	Татаас, санхүүжилтийн авлага	101,228,684.20	25,021,514.20
34	УРЬДЧИЛГАА	151,962,405.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	151,962,405.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	373,273,044.44	362,401,846.49
354	Хангамжийн материал	373,273,044.44	362,401,846.49
35410	Бичиг хэргийн материал	18,353,350.00	17,897,150.00
35420	Аж ахуйн материал	12,555,835.00	10,843,635.00
35430	Сэлбэг хэрэгсэл	16,621,636.00	16,521,636.00
35440	Түлш, шатах тослох материал	1,123,000.00	483,000.00
35450	Барилгын засварын материал	56,077,594.00	53,263,209.00
35470	Бусад хангамжийн материал	268,541,629.44	263,393,216.49
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,895,330,543.42	8,383,345,419.84
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,791,012,943.38	8,279,307,819.76
392	Биет хөрөнгө	8,791,012,943.38	8,279,307,819.76
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,594,553,520.00	7,594,553,520.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(253,151,784.00)	(379,727,676.00)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	257,207,600.00	257,207,600.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(106,152,005.64)	(140,353,272.36)
39205	Машин тоног төхөөрөм (компьютер)	1,940,339,642.23	1,957,908,742.23
39206	Хуримтлагдсан элэгдэл	(845,701,842.11)	(1,178,517,447.29)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	397,390,893.55	412,183,293.55
39208	Хуримтлагдсан элэгдэл	(201,400,740.65)	(251,939,600.37)
39217	Ном	7,927,660.00	7,992,660.00
393	Биет бус хөрөнгө	104,317,600.04	104,037,600.08
39301	Програм хангамж	124,150,000.00	124,150,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(122,749,999.96)	(123,029,999.92)
39303	Бусад биет бус хөрөнгө	102,917,600.00	102,917,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,521,794,677.06	8,770,768,780.53
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,281,910,343.49	9,281,910,343.49
51	Засгийн газрын хувь оролцоо	9,281,910,343.49	9,281,910,343.49
511	Засгийн газрын оруулсан капитал	9,281,910,343.49	9,281,910,343.49
51101	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	9,281,910,343.49	9,281,910,343.49
512	Хуримтлагдсан үр дүн	239,884,333.57	(511,141,562.96)
51210	Өмнөх үеийн үр дүн	239,884,333.57	239,884,333.57
51220	Тайлант үеийн үр дүн	-	(751,025,896.53)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,521,794,677.06	8,770,768,780.53

Соёлын өвийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	3,169,105,537.35	2,731,354,967.92
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	122,571,545.00	2,731,354,967.92
120	Нийтлэг татварын бус орлого	122,571,545.00	18,729,596.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	122,571,545.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	122,571,545.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого үндсэн хөрөнгө	-	18,729,596.40
122	Тусламжийн орлого	-	2,712,625,371.52
1221	Хандив тусламжийн /дотоод/	-	2,712,625,371.52
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт шилжүүлэгийн орлого	-	2,389,997,200.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	2,389,997,200.00
1221	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	322,628,171.52
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	268,524,572.32
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	46,924,099.20
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	7,179,500.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,046,533,992.35	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,125,080,100.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,125,080,100.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	921,453,892.35	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	217,594,397.85	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	691,960,494.50	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,899,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,697,303,328.18	3,482,380,864.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,697,303,328.18	3,482,380,864.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,477,084,541.13	3,321,131,284.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,560,957,745.03	1,708,578,318.19
210101	Үндсэн цалин	924,624,309.74	1,032,208,630.67

Соёлын өвийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210102	Нэмэгдэл	222,004,973.35	275,258,117.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	218,555,943.88	260,993,177.32
210104	Урамшуулал	195,772,518.06	140,118,393.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	195,649,975.09	212,469,505.23
210201	Тэтгэврийн даатгал	136,544,648.78	145,839,627.92
210202	Тэтгэмжийн даатгал	14,970,665.69	18,508,322.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,405,072.28	11,746,533.44
210204	Ажилгүйдлийн даатгал	7,147,501.80	8,333,687.68
210205	Эрүүл мэндийн даатгал	28,582,086.54	28,041,333.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,339,115.98	93,125,630.90
210301	Гэрэл, цахилгаан	26,679,704.71	32,396,248.49
210302	Түлш, халаалт	55,855,442.15	53,949,945.38
210303	Цэвэр, бохир ус	6,803,969.12	6,779,437.03
2104	Хангамж, бараа материалын зардал	104,544,521.05	110,361,005.04
210401	Бичиг хэрэг	8,474,200.00	5,827,000.00
210402	Тээвэр, шатахуун	29,566,000.00	28,966,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,203,240.40	5,813,432.09
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,028,500.00	215,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,949,566.00	19,608,360.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	45,240,481.65	37,787,162.95
210408	Бараа материал акталсны зардал	2,082,533.00	12,143,600.00
2105	Нормативт зардал	1,000,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,100,000.00	6,362,600.00
210604	Урсгал засвар	21,100,000.00	6,362,600.00
2107	Томилолт, зочны зардал	56,984,200.00	27,690,000.00
210702	Дотоод албан томилолт	56,984,200.00	27,690,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	821,700,879.00	566,209,520.08
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	817,279,381.00	564,209,520.08
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	517,860.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	289,130.00	-
210807	Газрын төлбөр	614,508.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	625,808,105.38	596,334,704.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,162,000.00	4,507,185.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,071,949.00	55,434,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	578,574,156.38	536,393,519.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	220,218,786.65	160,249,580.03

Соёлын өвийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	40,537,300.03
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг		40,537,300.03
213112	Төрийн байгууллагаас харьяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		40,537,300.03
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		40,236,730.51
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал		300,569.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	64,964,579.50	120,712,280.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	34,182,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	59,964,579.50	85,980,280.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	550,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	155,254,207.15	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	153,950,239.49	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,303,967.66	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(528,197,790,83)	(751,025,896.53)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(528,197,790,83)	(751,025,896.53)

Соёлын өвийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,104,868,392.35	2,813,854,055.72
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	2,813,854,055.72
122	Тусламжийн орлого	-	2,813,854,055.72
1221	Хандив тусламж /дотоод/	-	2,813,854,055.72
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт шилжүүлгийн орлого	-	2,389,997,200.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	2,389,997,200.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	423,856,855.72
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	279,983,761.52
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	136,693,594.20
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	7,179,500.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,104,868,392.35	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,125,080,100.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,125,080,100.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	979,788,292.35	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	217,594,397.85	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөв тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	750,294,894.50	-
131105	Төсвийн байгууллагын үнсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,899,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,086,618,792.35	2,808,175,255.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,086,618,792.35	2,808,175,255.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,765,171,321.50	2,621,904,161.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,560,957,745.03	1,708,578,318.19
210101	Үндсэн цалин	924,624,309.74	1,032,208,630.67
210102	Нэмэгдэл	222,004,973.35	275,258,117.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	218,555,943.88	260,993,177.32
210104	Урамшуулал	195,772,518.06	140,118,393.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	195,649,975.09	212,469,505.23
210201	Тэтгэврийн даатгал	136,544,648.78	145,839,627.92
210202	Тэтгэмжийн даатгал	14,970,665.69	18,508,322.34

Соёлын өвийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210203	ҮОМШӨ-ний даатгал	8,405,072.28	11,746,533.44
210204	Ажилгүйдлийн даатгал	7,147,501.80	8,333,687.68
210205	Эрүүл мэндийн даатгал	28,582,086.54	28,041,333.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,339,115.98	93,125,630.90
210301	Гэрэл, цахилгаан	26,679,704.71	32,396,248.49
210302	Түлш, халаалт	55,855,442.15	53,949,945.38
210303	Цэвэр, бохир ус	6,803,969.12	6,779,437.03
2104	Хангамж, бараа материалын зардал	85,702,776.40	69,664,942.09
210401	Бичиг хэрэг	18,152,100.00	7,306,500.00
210402	Тээвэр, шатахуун	30,636,000.00	28,966,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,203,240.40	5,813,432.09
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,028,500.00	215,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	29,682,936.00	27,363,560.00
2105	Нормативд зардал	1,000,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,000,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,800,000.00	6,523,200.00
210604	Урсгал засвар	23,800,000.00	6,523,200.00
2107	Томилолт, зочны зардал	56,984,200.00	27,690,000.00
210702	Дотоод албан томилолт	56,984,200.00	27,690,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	690,782,060.00	438,138,930.08
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	686,360,562.00	436,138,930.08
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	517,860.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	289,130.00	-
210807	Газрын төлбөр	614,508.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,955,449.00	65,713,635.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,883,500.00	7,801,185.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,071,949.00	57,912,450.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	321,447,470.85	186,271,094.23
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	65,558,814.23
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	65,558,814.23
213112	Төсвийн байгууллага харьяа төрийн сан уруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	65,558,814.23
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	40,236,730.51
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	300,569.52
2131126	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн шилжүүлгийн зардал	-	25,021,514.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	64,964,579.50	120,712,280.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	-	34,182,000.00

Соёлын өвийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	59,964,579.00	85,980,280.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	5,000,000.00	550,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	256,482,891.35	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	153,950,239.49	-
2133305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	102,532,651.86	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	18,249,600.00	5,678,800.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	18,249,600.00	5,678,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,249,600.00	5,678,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	18,249,600.00	5,678,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	18,249,600.00	5,678,800.00
6	Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	(18,249,600.00)	(5,678,800.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

Соёлын өвийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	<i>/төгрөгөөр/</i>
			Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,281,910,343.49	768,082,124.40	10,049,992,467.89
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,281,910,343.49	768,082,124.40	10,049,992,467.89
Тайлант үеийн үр дүн	-	(528,197,790.83)	(528,197,790.83)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,281,910,343.49	239,884,333.57	9,521,794,677.06
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,281,910,343.49	239,884,333.57	9,521,794,677.06
Тайлант үеийн үр дүн	-	(751,025,896.53)	(751,025,896.53)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,281,910,343.49	-511,141,562.96	8,770,768,780.53

Соёлын өвийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,400,774,400.00	2,349,760,469.49	51,013,930.51	97.9
12	Татварын бус орлого	2,400,774,400.00	2,349,760,469.49	51,013,930.51	97.9
122	Тусламжийн орлого	2,400,774,400.00	2,349,760,469.49	51,013,930.51	97.9
122005	Төсвөөс санхүүжих	2,400,774,400.00	2,349,760,469.49	51,013,930.51	97.9
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,400,774,400.00	2,349,760,469.49	51,013,930.51	97.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,400,774,400.00	2,349,760,469.49	51,013,930.51	97.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,279,360,500.00	2,229,048,189.49	50,312,310.51	97.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,738,995,200.00	1,703,703,318.19	35,291,881.81	98.0
210101	Үндсэн цалин	1,109,406,900.00	1,032,208,630.67	77,198,269.33	93.0
210102	Нэмэгдэл	272,726,300.00	275,258,117.00	(2,531,817.00)	100.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	244,874,500.00	260,993,177.32	(16,118,677.32)	106.6
210104	Урамшуулал	111,987,500.00	135,243,393.20	(23,255,893.20)	120.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	217,355,500.00	212,469,505.23	4,885,994.77	97.8
210201	Тэтгэврийн даатгал	147,821,900.00	145,839,627.92	1,982,272.08	98.7
210202	Тэтгэмжийн даатгал	17,516,400.00	18,508,322.34	(991,922.34)	105.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,965,300.00	11,746,533.44	(2,781,233.44)	131.0
210204	Ажилгүйдлийн даатгал	8,705,700.00	8,333,687.68	372,012.32	95.7
210205	Эрүүл мэндийн даатгал	34,346,200.00	28,041,333.85	6,304,866.15	81.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	93,178,300.00	93,125,630.90	52,669.10	99.9
210301	Гэрэл, цахилгаан	31,700,500.00	32,396,248.49	(695,748.49)	102.2
210302	Түлш, халаалт	53,497,400.00	53,949,945.38	(452,545.38)	
210303	Цэвэр, бохир ус	7,980,400.00	6,779,437.03	1,200,962.97	85.0
2104	Хангамж, бараа материалын зардал	21,934,400.00	15,333,800.09	6,600,599.91	69.9
210401	Бичиг хэрэг	4,979,900.00	296,000.00	4,683,900.00	5.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,985,300.00	4,418,917.09	1,566,382.91	73.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	996,100.00	215,000.00	781,100.00	21.6

Соёлын өвийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй ,түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	9,973,100.00	10,403,883.00	(430,783.00)	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,523,200.00	3,523,200.00	-	100.0
210604	Урсгал засвар	3,523,200.00	3,523,200.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	198,519,700.00	195,038,535.08	3,481,164.92	98.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	193,533,400.00	193,038,535.08	494,864.92	99.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,986,300.00	2,000,000.00	2,986,300.00	40.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,854,200.00	5,854,200.00	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,901,200.00	1,901,200.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэл дадлага хийх	3,953,000.00	3,953,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	121,413,900.00	120,712,280.00	701,620.00	99.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	121,413,900.00	120,712,280.00	701,620.00	99.4
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	34,182,000.00	34,182,000.00	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	86,681,900.00	85,980,280.00	701,620.00	99.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	550,000.00	550,000.00	-	100.0
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-	-	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	121	121	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	59	59	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	1	1	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	41	41	-	100.0
620004	Гэрээт ажилтан	17	17	-	100.0

Соёлын өвийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	57	57	-	100.0
650006	Соёл урлагийн салбарын төрийн Үйлчилгээний алба	42	42	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	15	15	-	100.0
66	НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	4	4	-	100.0
660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	4	4	-	100.0

Соёлын өвийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.6 Аудитын хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	423,856,855.72
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	423,856,855.72
122	Тусламжийн орлого	423,856,855.72
1221	Хандив тусламжийн /дотоод/	423,856,855.72
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	279,983,761.52
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	279,983,761.52
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	136,693,594.20
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,179,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	398,534,722.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	398,534,722.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	398,534,722.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,875,000.00
210104	Урамшуулал	4,875,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	55,371,142.00
210401	Бичиг хэрэг	7,010,500.00
210402	Тээвэр, шатахуун	28,966,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,394,515.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,999,677.00
2105	Нормативт зардал	9,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,500,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	27,690,000.00
210702	Дотоод албан томилолт	27,690,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	246,239,195.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	246,239,195.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59,859,435.00
	Бараа үйлчилгээний бусад зардал	5,899,985.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	53,959,450.00
IV	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	25,322,083.72
	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(25,322,83.72)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Соёлын өвийн үндэсний төвийн нь Монгол соёлын өвийг бүртгэх, судлах, хадгалах, сэргээн засварлах, авран хамгаалах, сурталчлах чиг үүрэг бүхий үйл ажиллагаа явуулдаг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм

Байгууллагын эрхэм зорилго

Монгол үндэстэн, угсаатны соёлын өвийн үнэ цэн орон зайн дархлааг бид хамтран хамгаалж, ирээдүйд өвлүүлэн үлдээнэ.

Алсын хараа

Төв болон зүүн хойд Азийн бүс нутагт соёлын өвийг хамгаалах олон улсын хамтын ажиллагааны төв болно.

Соёлын өвийн үндэсний төв нь Үндсэн чиг үүргийнхээ хүрээнд соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг мэргэжил арга зүй, олон нийтийг соёлын өвийн мэдлэг, боловсрол мэдээлэл хангаж, соёлын биет өвийг таньж тогтоох, материал бүтцийг шинжлэн судлах, түүх, соёлын урсгалын хүрээлэн буй орчны хадгалалт барилга, архитектурын дурсгалыг хамгаалах үйл ажиллагааг музей, эрдэм шинжилгээ судалгаа мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлж археологийн дурсгалаас илэрч олдсон олдвор, эд өлгийн зүйлсийг газар дээр нь болон тусгай лабораторид цэвэрлэх, бэхжүүлэх, музейн үзмэр, хөшөө, чулуун дурсгалыг сэргээн засварлах ажлыг зохион байгуулсаар ирсэн.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Соёлын өвийн үндэсний төв нь Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Төсвийн тухай хууль, “Төрийн албаны хууль”, “Хөдөлмөрийн тухай хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”, “Татварын багц хууль”, “Нийгмийн даатгалын тухай” хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд тус газрын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Тухайлбал:

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дахь заалт;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 15 дугаар зүйлийн 15.1.8, 15.2.7 дахь заалт;
- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр албан даалгавар;
- Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 05 дугаар албан даалгавар гаргасан байна.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Соёлын өвийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дотоод хяналт шалгалтын ажилтан түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Соёлын өвийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл сууриар* хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь санхүүгийн бүртгэл хөтөлж, тайлан бэлтгэж гаргах ажиллагаатай холбоотой Монгол улсын хууль, тогтоомж, журам болон Улсын Секторын Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын Стандартын (УСНББОУС гэх) Монгол улсын сангийн сайдын тушаалаар баталсан журам, заавар аргачлалын шаардлагад нийцсэн болно гэж тусгасан байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь хөрөнгийн үнэ шинэчлэлийн талаар тусгаагүй байгаагаас бусад бүртгэлийн бодлогын хувьд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Соёлын өвийн үндэсний төв нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 751,025.9 мянган төгрөгөөр буюу 7.89 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Авлага	101,228.7	25,021.5	76,207.2
Урьдчилгаа	151,962.4	-	151,962.4
Бараа материал	373,273.0	362,401.8	10,871.2
Үндсэн хөрөнгө	8,895,330.5	8,383,345.4	511,985.1
Нийт хөрөнгө	9,521,794.7	8,770,768.8	751,025.9
Засгийн газрын хувь оролцоо	9,521,794.7	8,770,768.8	751,025.9
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	9,521,794.7	8,770,768.8	751,025.9

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, Засгийн газрын хувь оролцоо данснууд байна. Үүнд:

Соёлын өвийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Авлагын дансны үлдэгдэл 76,207.2 мянган төгрөгөөр буурсан нь төсөлтэй холбоотой нэмэлт санхүүжилтийн авлагыг барагдуулан зарцуулсантай холбоотой байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 151,962.4 мянган төгрөгөөр буурсан нь урьдчилж төлсөн засвар үйлчилгээний ажил бүрэн хийж дууссантай холбоотой.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 511,985.1 мянган төгрөгөөр буурсан нь 5,678.8 мянган төгрөгийн принтер, зурагт, буйдан худалдан авч, 13,384.2 мянган төгрөгийн суурин компьютер принтер соёл, спорт аялал жуулчлал, залуучуудын яамнаас үнэ төлбөргүй, 13,363.5 мянган төгрөгийн танка зургийн тавиур Богд хааны орон музейгээс балансаас балансад тус тус шилжүүлэн авч, үндсэн хөрөнгөнд 536,393.5 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,734,023.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 1,363,192.0 мянган төгрөгөөр зардлыг бууруулж, 2,370,831.8 мянган төгрөгөөр баталжээ.

Төсвийн тодотголоор төсвийг 19,165.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нийт зардлыг 2,389,997.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,389,997.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 2,349,760.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 40,236.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,349,760.6 мянган төгрөг буюу 97.88 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын цалин хөлс болон нэмэгдэл урамшууллыг 30,416.9 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 8,675.6 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 4,758.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Бараа үйлчилгээний зардал	2,186,182.2	2,135,922.6	50,259.6	97.70
2	Байр ашиглалтын үйлчилгээ	93,178.3	93,125.6	52.7	99.94
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	120,413.9	120,712.3	701.6	99.42
4	Дүн	2,400,774.4	2,349,760.5	51,013.9	97.88

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

-Соёлын өвийн үндэсний төвийн захирлын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дугаар тушаалаар нийт 65 хүний орон тоо бүтэц баталж гүйцэтгэлээр 59 ажилтны орон тоогоор ажиллаж байна.

-Захирлын 2025 оны 01 дүгээр сарын 02-ний өдрийн А/01 дугаар тушаалд үндэслэн нэг хүнд ноогдох өдрийн хоолны зардал 20.0 мянган төгрөг, унааны мөнгө 2.0 мянган төгрөгөөр тооцоолон нийт 244,874.5 мянган төгрөгийн төсөвлөж, гүйцэтгэлээр 260,993.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

-Гадаад болон дотоод албан томилолтын зардал гараагүй.

-Хичээл сургалт үйлдвэрлэлийн зардалд 3,753.0 мянган төгрөг, японы сургалтад хамрагдсан 3 хүний хоолны зардал, аюулгүй ажиллагаа, төрийн албаны зөвлөлийн ёс зүйн сургалтад нийт ажилчдыг хамруулан 200.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төсөл хэрэгжүүлж, 423,856.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ. Үүнээс цалин хөлс нэмэгдэл урамшуулалд 4,875.0 мянган төгрөг, хангамжийн материалд 55,371.1 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 4,500.0 мянган төгрөг, дотоод томилолтын зардалд 27,690.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөрт 246,239.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 59,859.4 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 25,322.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлснийг 25,021.5 мянган төгрөгийг буцаан авах авлагаар тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант хугацаанд гэрээт харуул хамгаалалттай холбоотой 38,880.0 мянган төгрөгийн ажил үйлчилгээг худалдан авах төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сард батлуулж, харьцуулалтын аргаар “Шүтээн уул” ХХК ийг сонгон шалгаруулан гэрээ байгуулж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Соёлын өвийн үндэсний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Ирмүүн хантайшир аудит” ХХК-ийн ахлах аудитор Б.Норхлоо, аудиторын туслах Д.Отгонсэнгээ нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг Г.Сэр-Од, захирал Д.Бямбацэрэн, Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Лхагвацэнд аудиторын менежер И.Эрдэнэцэцэг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Соёлын өвийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/78 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн тайлангийн зардлын дүн 3,697,303.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 36,973.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага улсын төсвийн хөрөнгөөр олон нийтийг хамарсан шинэ жил аялал зугаалга зэрэг үйл ажиллагаа зохион байгуулахгүй, бичгийн цаас, хор зэрэг бичиг хэргийн зардлыг бууруулах зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн 245,263.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш нийт 245,263.6 мянган төгрөгийн орлогын 8 гүйлгээг байршуулаагүй.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд байршуулдаггүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Соёлын өвийн үндэсний төвийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хамруулан завсрын аудит гүйцэтгэж, мөнгөн хөрөнгө, авлага бараа материалын дансанд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитаар илэрсэн 8,750.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өгч, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин нягталж, дүнг аудитын тайланд тусгасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд 1,424.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, зөрчлийг арилгах 30,500.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгснийг 83.3 хувийн хэрэгжилттэй буюу 1 зөвлөмж хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,424.6	1	1,424.6	100
Албан шаардлага	1	30,500.0	1	30,500.0	100
Зөвлөмж	2	6,079.9	2	6,079.9	50
Нийт дүн	4	38,004.5	4	38,004.5	83.3

Шилэн дансны мэдээлэл дутуу байршуулсан зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй тул албан шаардлага хүргүүлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын хавсралтад заасан санхүүгийн тайлангийн маягтыг тодорхой болгож сайжруулах талаар эр бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 497,717.4 мянган төгрөгийн алдаа илэрснээс 3,274.0 мянган төгрөгийн зөрчлийг нөхөн төлүүлэх 1 төлбөрийн акт тогтоож, 61,703.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 432,740.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 зөвлөмж хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 497,717.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 460,744.4 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Нийт ажилтны ээлжийн амралтын цалингийн бодолтыг шалгахад 1 ажилтанд 3,274.0 мянган төгрөгийн амралтын мөнгийг ажилласан хоногийн цалинтай давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Амралтын болон ажилласан хоногийн цалинг давхардуулан олгосон зөрчлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

1. Соёлын өвийн үндэсний төвийн хэрэгжүүлж буй төслийн удирдлагын багт ажилласан тус соёлын өвийн захирал 13,041.2 мянган төгрөг, ерөнхий нягтлан бодогч 13,000.0 сая төгрөг, нийт 26,041.0 мянган төгрөгийг төслийн удирдагчийн цалин, санхүүгийн ажилтны урамшуулал хэлбэрээр тус газрын захирлын тушаалыг үндэслэн олгосон.

2. Мөн хэрэгжиж буй төслийн хүрээнд байгууллагын нягтлан бодогчийн хамаарал бүхий этгээдүүдэд томилолт, автомашины түрээсийн зардалд 21,462.0 мянган төгрөг, орчуулгын төлбөрт 14,200.0 мянган төгрөг, нийт 35,662.0 мянган төгрөгийг захирлын тушаалыг үндэслэн олгосон.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн заалтад нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Соёл, спорт, аялал, жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Салбарын хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга нарт зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авч биелэлтийг ирүүлэх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Соёлын өвийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 432,740.2 мянган төгрөгийн хөрөнгүүдийг зах зээлийн бодит үнээр үнэлж бүртгээгүй байна. Дээрх хөрөнгөнд 2021 онд Юнескогийн МҮК-аас Соёлын өвийн үндэсний төвд балансаас балансад шилжиж ирсэн синхрон орчуулгын багц төхөөрөмж 168 ширхэг 117,577.3 мянган төгрөгийн үнийн дүн бүхий ашиглалтын шаардлага хангадаггүй материаллаг хэмжээний хөрөнгө бүртгэлтэй байна.

Өгсөн зөвлөмж:

Анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгүүдэд дахин үнэлгээ хийж, ТӨБЗГ-аас зөвшөөрөл авч, бүртгэл тайланд тусгах арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Соёлын өвийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ажилтны ээлжийн амралтын мөнгийг ажилласан хоногийн цалинтай давхардуулж олгосон	1	3,274.0	1	3,274.0	-	-	-	-	-	-	-	-
2	Захирал, нягтлан нар болон нягтлан бологчийн хамаарал бүхий хүмүүст захирлын тушаалаар бэлэн мөнгө олгож ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн	1	61,703.2			1	61,703.2						
3	Элэгдлээрээ өртгөө нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгүүдэд ТӨБЗГ-г хүсэлт гарган арга үнэлгээ хийж бүртгээгүй.	1	432,740.2					1	432,740.2				
	Дүн	3	497,717.4	1	3,274.0	1	61,703.2	1	432,740.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1.	Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш орлогын 8 гүйлгээг байршуулаагүй.	1	245,263.6			1	245,263.6				
	Дүн	1	245,263.6			1	245,263.6				



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 118/00150/20

Улаанбаатар хот

СМГ-2026/000/МА-СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Соёлын өвийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийт ажилтны ээлжийн амралтын цалингийн бодолтыг шалгахад 1 ажилтанд 3,274,000.00 (гурван сая хоёр зуун далан дөрвөн мянга) төгрөгийн амралтын мөнгийг ажилласан хоногийн цалинтай давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Амралтын мөнгийг ажилласан хоногийн цалинтай давхардуулан олгосон 3,274,000.00 (гурван сая хоёр зуун далан дөрвөн мянган) төгрөгийг буруутай албан тушаалтан хүний нөөцийн мэргэжилтэн Ц.Байгальмаа, Ерөнхий нягтлан бодогч Ч.Өнөртогтох нараар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлж, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёлын өвийн үндэсний төвийн захирал /Г.Энхбат/ хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"ИРМҮҮН ХАНТАЙШИР АУДИТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Д.БЯМБАЦЭРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

ATA16057
9022021411

Z:\Akt_2026\0225_SAG-69.Docx

1526200080



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 545/20150122

Улаанбаатар хот

САН-2026/200/НА-СТА-ТЦЗ

ЗӨРЧИЛ ТАСЛАН ЗОГСООХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Соёлын өвийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Соёлын өвийн үндэсний төвийн хэрэгжүүлж буй төслийн удирдлагын багт ажилласан тус Соёлын өвийн үндэсний төвийн захирал 13,041,200.00 (арван гурван сая дөчин нэгэн мянга хоёр зуу) мянган төгрөг, Ерөнхий нягтлан бодогч 13,000,000.00 (арван гурван сая) төгрөг, нийт 26,041,200.00 (хорин зургаан сая дөчин нэгэн мянга хоёр зуу) төгрөгийг төслийн удирдагчийн цалин, санхүүгийн ажилтны урамшуулал хэлбэрээр тус газрын захирлын тушаалыг үндэслэн олгосон.
2. Мөн хэрэгжиж буй төслийн хүрээнд байгууллагын Ерөнхий нягтлан бодогчийн хамаарал бүхий этгээдүүдэд томилолт, автомашины түрээсийн зардалд 21,462,000.00 (хорин нэгэн сая дөрвөн зуун жаран хоёр) төгрөг, орчуулгын төлбөрт 14,200,000.00 (арван дөрвөн сая хоёр зуун мянга) төгрөг, нийт 35,662,000.00 (гучин таван сая зургаан зуун жаран хоёр мянга) төгрөгийг захирлын тушаалыг үндэслэн олгосон.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн заалтад нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй байх” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Соёлын өвийн үндэсний төвийн нэрээр гэрээ байгуулан бусад эх үүсвэрээс санхүүжилт авч хэрэгжүүлсэн төслүүдийн зарцуулалтыг шалгаж, ашиг сонирхол үүссэн эсэх, санхүүгийн тайлагналын нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдлийг хангаж байгаа эсэхэд дотоод хяналт, шалгалт хийж, зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авч биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Соёл, спорт, аялал, жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Б.Бат-Эрдэнэ/ Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Ч.Энх-Амгалан/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
“ИРМҮҮН ХАНТАЙШИР АУДИТ” Д.БЯМБАЦЭРЭН
ХХК-ИЙН ЗАХИРАЛ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 546/00150122

Улаанбаатар хот

С ГТ - 2026 / 200 / НА - СТА - ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Соёлын өвийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 245,263,650.00 (хоёр зуун дөчин таван сая хоёр зуун жаран гурван мянга зургаан зуун тавин) төгрөгийн орлогын гүйлгээг мэдээлээгүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг” 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр гэж заасан мэдээллийг байгууллага долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.8-д байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй ” гэж заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлдэггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёлын өвийн үндэсний төвийн захирал /Г.Энхбат/, Ерөнхий нягтлан нягтлан бодогч /Ч.Өнөртогтох/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
“ИРМҮҮН ХАНТАЙШИР АУДИТ”
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Д.БЯМБАЦЭРЭН





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 118/00150/20

Улаанбаатар хот

СМГ-2026/000/МА-СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Соёлын өвийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийт ажилтны ээлжийн амралтын цалингийн бодолтыг шалгахад 1 ажилтанд 3,274,000.00 (гурван сая хоёр зуун далан дөрвөн мянга) төгрөгийн амралтын мөнгийг ажилласан хоногийн цалинтай давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Амралтын мөнгийг ажилласан хоногийн цалинтай давхардуулан олгосон 3,274,000.00 (гурван сая хоёр зуун далан дөрвөн мянган) төгрөгийг буруутай албан тушаалтан хүний нөөцийн мэргэжилтэн Ц.Байгальмаа, Ерөнхий нягтлан бодогч Ч.Өнөртогтох нараар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлж, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёлын өвийн үндэсний төвийн захирал /Г.Энхбат/ хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"ИРМҮҮН ХАНТАЙШИР АУДИТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Д.БЯМБАЦЭРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

АТ.14057
902031411

Z:\Akt_2026\0225_SAG-69.Docx

1526200080



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 545/20150122

Улаанбаатар хот

САН-2026/200/НА-СТА-ТЦЗ

ЗӨРЧИЛ ТАСЛАН ЗОГСООХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Соёлын өвийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Соёлын өвийн үндэсний төвийн хэрэгжүүлж буй төслийн удирдлагын багт ажилласан тус Соёлын өвийн үндэсний төвийн захирал 13,041,200.00 (арван гурван сая дөчин нэгэн мянга хоёр зуу) мянган төгрөг, Ерөнхий нягтлан бодогч 13,000,000.00 (арван гурван сая) төгрөг, нийт 26,041,200.00 (хорин зургаан сая дөчин нэгэн мянга хоёр зуу) төгрөгийг төслийн удирдагчийн цалин, санхүүгийн ажилтны урамшуулал хэлбэрээр тус газрын захирлын тушаалыг үндэслэн олгосон.
2. Мөн хэрэгжиж буй төслийн хүрээнд байгууллагын Ерөнхий нягтлан бодогчийн хамаарал бүхий этгээдүүдэд томилолт, автомашины түрээсийн зардалд 21,462,000.00 (хорин нэгэн сая дөрвөн зуун жаран хоёр) төгрөг, орчуулгын төлбөрт 14,200,000.00 (арван дөрвөн сая хоёр зуун мянга) төгрөг, нийт 35,662,000.00 (гучин таван сая зургаан зуун жаран хоёр мянга) төгрөгийг захирлын тушаалыг үндэслэн олгосон.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн заалтад нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй байх” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Соёлын өвийн үндэсний төвийн нэрээр гэрээ байгуулан бусад эх үүсвэрээс санхүүжилт авч хэрэгжүүлсэн төслүүдийн зарцуулалтыг шалгаж, ашиг сонирхол үүссэн эсэх, санхүүгийн тайлагналын нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдлийг хангаж байгаа эсэхэд дотоод хяналт, шалгалт хийж, зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авч биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Соёл, спорт, аялал, жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Б.Бат-Эрдэнэ/ Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Ч.Энх-Амгалан/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР  И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
“ИРМҮҮН ХАНТАЙШИР АУДИТ”  Д.БЯМБАЦЭРЭН
ХХК-ИЙН ЗАХИРАЛ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 546/00150122

Улаанбаатар хот

С ГТ - 2026 / 200 / НА - СТА - ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Соёлын өвийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 245,263,650.00 (хоёр зуун дөчин таван сая хоёр зуун жаран гурван мянга зургаан зуун тавин) төгрөгийн орлогын гүйлгээг мэдээлээгүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг” 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр гэж заасан мэдээллийг байгууллага долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.8-д байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй ” гэж заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлдэггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёлын өвийн үндэсний төвийн захирал /Г.Энхбат/, Ерөнхий нягтлан нягтлан бодогч /Ч.Өнөртогтох/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
“ИРМҮҮН ХАНТАЙШИР АУДИТ”
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Д.БЯМБАЦЭРЭН

